Төрийн албан хаагчийн ёс зүйн судалгаа

Хүний нөөцийн мэргэжилтэн
М.Оюун-Ундрам

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО:

Төвийн албан хаагчдын ёс зүйн тухай ойлголтыг судлан төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг хэрхэн дагаж мөрдөж буйг илрүүлж, ёс зүйн хэм хэмжээг сурталчлан таниулах зорилготой.

Судалгааны арга зүй:

Судалгааг 17 асуулгын хүрээнд боловсруулж, Google doc програм ашиглан нийт 17 ажилтнаас түүврийн аргаар онлайнаар авсан.

Төвийн ажилтны мөрдөж буй ёс зүйн хэм хэмжээ

- Монгол улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”,
- Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”
- Төвийн захирлын 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өөдрийн А/57дугаар тушаалаар батлагдсан “Ажилтны ёс зүйн дүрэм”



Уг асуулгад нийт судалгаанд хамрагдагсдын 70 хувь нь төрийн ажлыг үнэнч шударгаар гүйцэтгэж чаддаг, 41 хувь нь шударгаар гүйцэтгэхийг хичээдэг гэсэн хариулт өгсөн. Энэ нь ажилтнууд өөрийн ажлаа гүйцэтгэхдээ ёс зүйн хэм хэмжээг баримталдаг болохыг харуулж байна.

Тухайн ажлыг ёс зүйн хэм хэмжээнд гүйцэтгэхэд сэтгэл ханамж, өндөр цалин, шудрага үнэлгээ, урамшуулал, дэмжлэг туслалцаа нөлөөлдөг гэсэн хариултыг судалгаанд хамрагдагсад өгсөн байна



Төрд өөрийн хувь нэмрийг оруулах нь төрийн албанд анх орсон шалтгаан гэсэн хариултыг ажилтны 88 хувь нь өгсөн байна. Энэ нь Улс орныхоо хөгжил цэцэглэлтэд оруулж буй хувь нэмэр бол өөрийн хариуцсан ажил үүргийг нэр төртэй, ёс зүйтэй шудрагаар гүйцэтгэх нь чухал гэсэн ойлголттой байна

Судалгаанд хамрагдагсдын 50 хувь нь танил талынхаа дэмжлэгээр ажилд анх орсон гэсэн хариулт өгсөн нь аливаа төрийн байгууллага ажилд авахдаа шудрага сонгон шалгаруулалт явуулдаггүй, танил тал, намын харъаллаар ажилд авдаг, чадварлаг хүний нөөц бүрдүүлж чадахгүй байгаатай холбоотой



Судалгаанд хамрагдсан ажилтны 64 хувь нь өөрийн ажилтай холбоотойгоор гаргасан шийдвэртээ бүрэн хариуцлага хүлээнэ гэсэн хариулт өгсөн нь ажилтнууд ёс зүйн чадвартай байгааг илтгэж байна.



Ажлаа хийх үедээ бусдад давуу байдал олгож огт болохгүй гэсэн хариултыг судалгаанд оролцогчдын 82 хувь нь хариулсан байна.

Таныг ажил үүргээ гүйцэтгэх явцад хэн нэгэн хүн хууль бус туслалцаа хүсвэл та ямар хариу үйлдэл үзүүлэх вэ?

17 responses



Ажил үүргээ гүйцэтгэх явцад хэн нэгэн хууль бус туслалцаа хүсвэл боломжгүй гэсэн хариулт өгнө гэж судалгаанд оролцогчдын 88 хувь нь хариулсан байна. Энэ нь ажилтнууд ёс зүйн хэм, хэмжээний талаар ойлголт сайтай байгааг харуулж байна.

Таны ажилтай чинь холбоотойгоор танд хууль бус санал тавих боломжтой хүнийг нэрлэвэл (жишээлбэл торгуулиа аргалуулах)

17 responses





Төрийн албанд тушаал дэвшихэд нэн түрүүнд тухайн хүний ажлын ур чадвар, мэргэшсэн байдал нөлөөлнө гэж ажилтнуудын 58 хувь нь үзжээ

Танай байгууллагад бусадтай соёлгүй харьцдаг албан хаагчид хэр олон байдаг вэ?

17 responses



Танай байгууллагад хов жив хөөцөлдсөн, ажлын цагийг үр дүнгүй өнгөрөөдөг албан хаагчид хэр олон байдаг вэ?

17 responses



Судалгаанд оролцогчдын ихэнх нь бусадтай соёлгүй харьцдаг, хов жид хөөцөлддөг ажилтан байхгүй гэсэн хариулт өгсөн нь байгууллагын соёл, хамт олны уур амьсгал эерэг байгааг харуулж байна

Ажлын цагаар хувийн ажлаа амжуулах тохиолдол хэр олон байдаг вэ?

17 responses



Судалгаанд оролцогчдын ихэнх нь хувийн ажлаа ажлын цагаараа хийдэггүй, цайны цагтаа багтаагаад амжуулдаг, ажлын цаг ашиглалт сайтай гэсэн хариулт өгсөн байна.

Байгууллагын эд зүйлийг хувийн хэрэгцээндээ ашиглах тохиолдол хэр олон байдаг вэ? (жишээ нь принтер ашиглах)

17 responses



Байгууллагын өмчийг хувийн хэрэгцээнд ашиглах тохиолдол огт гардаггүй гэсэн хариултыг ажилтнууд өгсөн нь ёс зүйтэй байгааг илтгэж байна

Танай байгууллагад ажлын байран дээр согтууруулах ундаа хэрэглэх эсвэл согтуу ажилдаа ирэх тохиолдол хэр олон байдаг вэ?

17 responses



Судалгаанд оролцогчид ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх, согтуугаар ажилдаа ирэх тохиолдол огт байхгүй гэдгийг илэрхийлсэн байна

Танай ажлын байран дээр зохисгүй хувцастай ажилладаг албан хаагч хэр олон байдаг вэ?

17 responses



Ажлын байранд зохистой хувцаслах нь ёс зүйтэй байгааг илтгэдэг гэдгийг судалгаанд оролцогчдын хариулт харуулж байна

Судалгааны дүгнэлт

Судалгаанд оролцогчдын нэр хүнд, тэдний ашиг сонирхлыг хамгаалах үүднээс судалгааг далд хэлбэрээр зохион байгуулсан нь илүү үнэнд дөхсөн судалгааны үр дүн гарах магадлалыг нэмэгдүүлсэн. Уг судалгааг авснаар төвийн ажилтнуудын ёс зүйн тухай ойлголт, ёс зүйн хэм хэмжээг хэрхэн баримталдаг болохыг илрүүлж, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг дүгнэх нэг шалгуур болох юм. Ёс зүй бол төрийн албан хаагчийн хувьд хариуцлагын хэм хэмжээ бөгөөд тодорхой ажил үйлс эрхэлж байгаа хүний зүгээс нийгэмтэйгээ харилцах, хариуцлага хүлээх, олны дунд биеэ авч явах, хүнтэй харилцах соёл, сайн сайхан, зан үйлийн уламжлалт хэм хэмжээний нэгдмэл систем болно. Ёс зүйг төлөвшүүлэх үйл ажиллагаа нь нэг талаас ажилтны хувийн зохион байгуулалт, ажил хариуцах чадвар, соёлын түвшин, зан байдал, сэтгэлгээний хандлагаас хамаарах боловч нөгөө талаас удирдлагын ажилтантай харьцах харьцаа, амьдралын хэв маяг, удирдах арга барил, орчин үеийн сэтгэлгээний чиг хандлагаас хамаарч байгааг анхаарах нь зүйтэй.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

- Төвийн мөрдөж буй дүрэм, журамд тулгуурласан ёс зүйн хандлагыг шударга зарчимч байхад тулгуурласан ёс зүйн төлөвшил, хөгжлийн хандлагатай хослуулан хэрэглэх.

- Ажилтны ёс зүйн дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэхэд чиглэсэн олон талт сургалт сурталчилгааны арга хэмжээнүүдийг зохион байгуулах, шилдэг туршлагыг нэвтрүүлэх